

БАТЛАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА..... / А.ЭНХБАТ/

ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН.
“ЖИНКОРОНА” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../ Н.БАТЦЭНГЭЛ /

НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ ОРШИХ
“ЖИНКОРОНА” ХХК-ийн ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ НООС,
НООЛУУР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨСЛИЙН 2022 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 5060869

ХЯНАСАН:
Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын
газрын мэргэжилтэн...../ П.Шинэцэцэг /

БОЛОВСРУУЛСАН:
“Жинкорона” ХХК-ийн байгаль орчны
мэргэжилтэн...../Д.Золжаргал /

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, АЖЛЫН БИЕЛЭЛТ	3
1.2 Үйлдвэрийн хүчин чадал, биелэлт	4
1.3 Төслийн технологи	4
1.4 Түүхий эд туслах материал	4
1.5 Төслийн усан хангамж	4
1.6 Цахилгаан эрчим хүч, уур дулааны эх үүсвэр	5
1.7 Химийн бодис	5
ХОЁР. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	6
2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээий төлөвлөгөөний биелэлт	6
2.1.1. Агаарын чанар хог хаягдлаар бохирдох	8
2.1.2. Агааржуулалт	10
2.1.3. Ажлын байрны агаарын чанар	10
2.1.4. Ариутгал	10
2.1.5. Төхөөрөмжийн засвар үйлчилгээ	11
2.1.6. Ус ашиглалт, гэрээ	11
2.1.7. Бохир усны шинжилгээ	13
2.1.8. Бага оврын цэвэрлэх байгууламж	13
2.1.9. Ундны усны шинжилгээ	14
2.1.10. Тунгаагуур цэвэрлэгээ	14
2.1.11. Усны төлбөр	14
2.1.12. Хөрсний шинжилгээ	15
2.1.13. Гадна талбайн цэвэрлэгээ	15
2.1.14. Хог хаягдлыг цуглуулан тээвэрлэх	15
ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	16
ДӨРӨВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	18
ТАВ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ	22
ЗУРГАА. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	23
6.1. Агаарын шинжилгээ	23
6.2. Усны хяналт шинжилгээ	24
6.3. Хөрсний шинжилгээ	25
ДҮГНЭЛТ	26

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, АЖЛЫН БИЕЛЭЛТ

Төслийн нэр:	“Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр” -ийн төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	Хувийн хөрөнгө оруулалттай “Жинкорона” ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9011028109, Регистрийн дугаар: 5060869
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 5-р хороо, 6-р хороолол, 49-2, 11 тоот. Утас: 99117819
Төслийн байршил	Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт 0.84 га талбайд байрлана.



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршилын зураг



Зураг 2. Төсөл хэрэгжих үйлдвэрийн байр

1.2 Үйлдвэрийн хүчин чадал, биелэлт

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр нь жилд 700 тн ноос, ноолуур боловсруулах хүчин чадалтай ажилладаг. Хятад улсад үйлдвэрлэгдсэн автомат ажиллагаа бүхий LB-023-152 маркийн ноос угаах машинтай, ноос хүлээн авах, дамжуулан угаах болон шавхагч, хатаагч машинууд, пресслэгч аппаратаар тоноглогдсон. Дээрх машин, төхөөрөмжүүд нь угсраа дамжлага хэлбэрээр ажиллах бөгөөд бүрэн автоматжсан байна.

Тус онд манай үйлдвэр ноос угаагаагүй, 573 ноолуур угаагаад байна.

1.3 Төслийн технологи

Тус компаний ноолуур боловсруулах үйлдвэр нь шугаман функциональ зохион байгуулалтын бүтэцтэй бөгөөд түүнд түүхий эд /ноолуур/ бэлтгэх ба хүлээн авах, нөөцлөн хадгалах, ангилан ялгаж төрөлжүүлэх, сэгсрэх, угаах, хатаах, самнаж хялгасыг нь ялгах, пресслэж боох зэрэг технологи дараалалтай байна. Үйлдвэрлэлийн технологийн ерөнхий схемийг дараах зургаар харуулав.



Зураг 3. Ноолуурын үйлдвэрийн технологийн схем

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр нь ямааны ноолуурыг өнгөөр ангилан ялгах, түүнийг хүлээн авах, сэвсийлгэх, сэгсэрч механик хольцоос нь цэвэрлэх, угаах, хатаах, хялгас ялгаж самнах замаар боловсруулах зэрэг үйл ажиллагааг үйлдвэрлэлийн цехэд явуулахаар төлөвлөсөн байна.

Үйлдвэрийн технологийн шийдлийн гол зорилт нь ноолууран түүхий эдийг угааж хялгасыг нь ялгах замаар түүний боловсруулалтын түвшинг дээшлүүлэн олон улсын стандартын шаардлагад тохирох экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэж гадаад зах зээлд нийлүүлэх асуудал юм .

1.4 Түүхий эд туслах материал

Тус үйлдвэр нь түүхий эд бэлтгэлийг баруун зүгийн засмал замын дагуу орших, Эмээлтийн орчимд өөрийн ноолуур хүлээн авах түрээсийн газраараа дамжуулан бэлтгүүлж, ноолуурыг өнгө, микроноор /дундаж голч/ нь ялган, ялгавартай үнээр худалдан хүлээж авдаг байна.

1.5 Төслийн усан хангамж

Үйлдвэрийн зориулалттай усыг өөрийн талбайд гаргасан гүний худгаас хангадаг ба Нийслэлийн байгаль орчны газартай 2022 оны 09 дугаар сарын 06-ны өдрийн 2022/57 дугаар ус ашиглах гэрээ байгуулан ажилласан.

2022 онд үйлдвэр нийт 21909.6 м³ ус ашиглан 2,068,266 төгрөгийг Сонгинохайрхан дүүргийн татварын албанд төлсөн. Ажилчдын ахуйн хэрэглээний усыг төвийн шугамаас хангаж байна.

1.6 Цахилгаан эрчим хүч, уур дулааны эх үүсвэр

Манай үйлдвэр нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20 –р хорооны нутаг дэвсгэрт байрладаг. Тус үйлдвэр цахилгаан эрчим хүч, дулаан хангамжаа Төвийн эрчим хүчний нэгдсэн шугамд холбогдон хангаж байна.

1.7 Химийн бодис

Үйлдвэр нь ноос, ноолуурын угаалгад зориулж шингэн, хатуу 2 төрлийн саванг уусмал хэлбэрээр бэлтгэж хэрэглэдэг бөгөөд тус саванг БОАЖЯ—ны химийн хорт болон аюултай бодис ашиглах, импортлох 0001929 дугаар тусгай зөвшөөрлийн дагуу авч Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2017 оны 03 дугаар сарын 23-ны 02-04-373/199 дугаар химийн бодисын агуулхын дүгнэлтэд тусгасан MNS 6458:2014, MNS 4996:2000 стандартыг хангасан агуулхад зориулалтын дагуу хадгалан ашиглаж байна.

ХОЁР. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Биелэлт	Хувь
2.1.1.	Үйлдвэрийн ангилан ялгах, хялгас ялгах гэх мэт зарим цех тасгуудын технологийн процессоос гарах тоосжилт, чимээ шуугиан нь үйлдвэрийн ажлын байрны бохирдолтод нөлөөлөөд зогсохгүй орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болно.	Хатуу болон шингэн хаягдлаар агаар бохирдохоос сэргийлэх арга хэмжээ авах	Хатуу хог хаягдлын тусгайлсан цементэн хучилттай цэгт үйлдвэрийн хатуу хог хаягдлыг төвлөрүүлэн Сонгинохайрхан дүүргийн ТҮК-тэй байгуулсан гэрээний дагуу нийлүүлж байна.	100%
2.1.2.		Тоосжилт ихтэй хэсэгт /ангилан ялгах ширээний доор/ агааржуулалтын нэмэлт төхөөрөмж тавих	Үйлдвэрийн байранд агааржуулалтын системийг хангалттай хэмжээнд суурилуулан ажиллагааг тогтмол шалгаж байна.	100%
2.1.3.		Агаар дахь хорт боисын хэмжээг ЗДХ-ээс хэтрүүлэхгүй байх, ажлын байрны агаарын темпратур, гэрэлтүүлэг, чийглэгийн хэмжээг хянаж, стандартад заасан хэмжээнд байлгах	Агаарын чанар. Техникийн шаардлага MNS 4585:2016 стандартын хүлцэх хэмжээг баримтлан ажилладаг ба үйлдвэрээ агаарын чанарын 1 дээж авч шинжлүүлсэн. /Дэлгэрэнгүйг ОХШХ-т тусгав/.	100%
2.1.4.		Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэх	“Энх цагийн үйлс” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу сард 1 удаа үйлдвэрийн талбай, гадна талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэж байна.	100%
2.1.5.		Чимээ ихтэй тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ, шинэчлэл хийх арга хэмжээ авах	Тус онд үйлдвэрийн тоног төхөөрөмжинд гэмтэл гараагүй болно.	-
2.1.6	Үйлдвэрлэлийн зориулалтаар ус хэрэглэх тул усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.	Үйлдвэрийн зориулалтаар их хэмжээний ус ашиглах тул усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, Ус хэрэглээний нормыг цех бүр дээр нарийвчлан тогтоох, түүнд үндэслэн ус ашиглалтын гэрээг холбогдох газартай хийх	Үйлдвэр нь Туул голын сав газарт хамаарагдана. Төслийн усан хангамжийг өөрийн эзэмшлийн 1 худгаас хангадаг ба Туул голын сав газартай байгуулсан ус ашиглах гэрээний дагуу 21909.6 м ³ ус ашиглан гэрээний дүгнэлтийг хийж төлбөрийг төлсөн.	100%
2.1.7.	Хаягдал бохир ус стандартад заасан хэмжээнээс давах, улмаар сөрөг нөлөөлөл үзүүлэх	Үйлдвэрээс гарч буй бохир усанд шинжилгээ хийлгэж, тэмдэглэл хөтөлж байх	ОХШХ-т тусгав.	100%
2.1.8.	Үйлдвэрээс гарах бохир ус, хатуу хог хаягдлыг цуглуулах, цэвэрлэх, зайлуулах үйл ажиллагаа зохих журмын дагуу хийгдээгүйгээс газрын доорх ус бохирдох,	Ноолуур угаасан усыг эргүүлэн дахин ашиглах технологи судлан нэвтрүүлэх, бага оврын цэвэрлэх байгууламж барьж ашиглалтанд оруулах	Үйлдвэрээс гарч буй хаягдал усыг бага оврын цэвэрлэх байгууламжинд цэвэрлэн MNS 6561:2015 ХБО. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага стандартанд нийцүүлэн төвлөрсөн системд нийлүүлж байна.	100%
2.1.9.		Унд-ахуйн усны чанарт хяналт тавих зорилгоор химин-нян судлалын шинжилгээ хийлгэж байх	Үйлдвэрийн худгаас дээж авсан ба ОХШХ-т тусгав.	100%

“Жинкорона” ХХК -ийн Сонгинохайрхан дүүргийн 20 -р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр” -ийн төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Биелэлт	Хувь
2.1.10.	цэвэрлэх байгууламжийн ажиллагааны горимыг алдагдуулах;	Үйлдвэрийн дотор трап болон гадна худаг, тунгаагуурыг цэвэрлэх	Үйлдвэрийн ажилчдыг томилон 7 хоногт 1 удаа цэвэрлэв.	100%
2.1.11.		Тоолуурын заалтын дагуу ус ашигласаны төлбөрийг төлөх	Тус онд 21909.6 м ³ ус ашиглан 2,068,266 төгрөгийг Сонгинохайрхан дүүргийн татварын албанд төлсөн.	100%
2.1.12.	Үйлдвэрээс гарах бохир ус, хатуу хог хаягдлыг цуглуулах, зайлуулах үйл ажиллагаа зохих журмын дагуу хийгдээгүйгээс орчны хөрс бохирдох нөхцөлтэй; Технологийн горимыг зөрчих, ажиллагсдын хайнга үйл ажиллагааны улмаас орчны хөрсөнд бохирдол үүсэх;	Үйлдвэрийн хаягдал бохир ус, угаалгын бодисоор хөрс бохирдож болзошгүй тул хөрсний бохирдлын хэмжээг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулж байх	ОХШХ-т тусгав.	100%
2.1.13.		Үйлдвэрийн гадна талбайд цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж байх	Үйлдвэрийн ажилчдыг хамруулан гадна талбайн цэвэрлэгээ, арчилгааг сард 1 удаа хийж байна.	100%
2.1.14.		Үйлдвэрлэлийн болон ахуйн хатуу хог хаягдлыг тодорхой хугацаанд хог хаягдлын нэгдсэн цэгт зайлуулж байх	Сонгинохайрхан дүүргийн ТҮК-тэй байгуулсан гэрээний дагуу сард 1 удаа зайлуулж байна.	100%
2.1.15.	Үйлдвэр болон ахуйн гаралтай хатуу, шингэн хаягдлаар хөрс бохирдох.	Хатуу хог хаягдлын цэгийг хатуу хучилттай болгох	Хатуу хучилттай болгохоор талбайг бэлтгэх ажил хийгдэж байна.	0%

Шингэн хаягдлыг бага оврын цэвэрлэх байгууламж байгуулан MNS 6561:2015 ХБО. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага стандартанд нийцүүлэн төвлөрсөн системд нийлүүлж байна.

Үйлдвэрийн үйл ажиллагаанд шингэн саван ашигладаг гарсан хаягдлыг зориулалтын дагуу хадгалан “Цэцүүх трейд” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу нийлүүлж байна.



Зураг 6. Шингэн саван хадгалах агуулах, тусгай зөвшөөрөл



Зураг 7. Аюултай хог хаягдлын гэрээ

“Жинкорона” ХХК -ийн Сонгинохайрхан дүүргийн 20 -р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр” -ийн төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Батлав
"Энх цагийн үйлс" ХХК
Захирагч: М.Н. Баянмөнх

Ариутгал халдваргүйтэл, шавьж мэргэчин устгал хийх, хамтран ажиллах гэрээ

2022 оны 03-р сарын 01-ны өдөр № 01 Улаанбаатар хот

Нэг талаас: Мин Корона ХХК "Шавьж" Захиалагч гэрээг нөгөө талаас 5318589 тоот регистрийн дугаартай "Энх цагийн үйлс" ХХК ахуйн шавьж мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтийн үйлчилгээ үзүүлэгчид "Гүйцэтгэгч" гэрээ харилцан тохиролцооны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

Нэг: Гэрээний зорилго

Энэхүү гэрээний зорилго нь үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын шавьж, мэрэгч устгал, ариутгал халдваргүйтэлтийн ажлыг стандартын шаардлага хангасан төхөөрөмж, технологийн гэрээний журмын дагуу явуулах мөн зөвшөөрөгдсөн ариутгал халдваргүйжүүлэлт, шавьж мэргэчин ахуйн өсгөлт, гаралтай барихад бодис хэрэглэх хувийг багасгах, амьдрах нөхцөл боловсрол бүрдүүлэх зорилготой энэхүү гэрээг байгуулав.

Хоёр: Гүйцэтгэгч байгууллагын үүрэг

1. Үйлчилгээний захиалгыг биеэр болон угсаар хүлээн авна.
2. Ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйлчилгээ олон улсын стандартын шаардлага хангасан хор, бодисоор технологийн заваран дагуу чанартай хийж гүйцэтгэнэ.
3. Үйлчилгээ талын мэргэжлийн хамт үйлчилгээ хийхгэр өрөө тасалганы тоо, талбайн хэмжээг тооцон гаргана.
4. Үйлчилгээнд хэрэглэх хор бодисын өсгөлт, асуулыг ажиллаганы талар мэргэжлийн зөвлөөг өгч, үйлчилгээ хийх өдөр, цаг, давтамжийг тооцоо, үйлчилгээний төлбөрийг тооцоо.
5. Үйлчилгээний хойш тодорхой хугацаанд эргэн тэнцэт хийж, цашид авах арга хэмжээг төлөвлөнө.
6. Үйлчилгээний төлбөрийг тогтоосон хугацаанд нь барьгдуулахад шаардах эрхтэй.

- 2.7 Гэрээ үндэслэн ариутгал халдваргүйжүүлэлт хийж мэдээг 7 хоногийн өмнө үйлчлүүлэгч байгууллагад мэдэгдэж, урьдчилан бэлтгэлийг бүрэн хангасан байна.
- Гурав: Захиалагч байгууллагын үүрэг
- 3.1 Үйлчилгээний захиалгыг угас болон биеэр очиж авна.
- 3.2 Үйлчилгээ хийлгэх газрын өрөө тасалганы тоо, талбайн хэмжээг танилдуулж, үйлчлүүлэх талбай, үйлчилгээний төрөл, давтамжийг тооцоо.
- 3.3 Гүйцэтгэгч талд тухайн байгууллагад халдвар өвчний тохиолдол бүртгэгдсэн эсэх, шавьж мэргэчин тархалт, төрөл зүйлийн талаар үнэн бодит мэдээлэл өгнө.
- 3.4 Гүйцэтгэгч байгууллагаас өсгөн үйлчилгээний өмнө ба дараа барилгын зааврыг чанд мөрдөнө.
- 3.5 Үйлчилгээний чанар хэрэглэх буй хор бодисын чанарт хяналт тавина.
- 3.6 Үйлчилгээний төлбөрийг хугацаанд нь барагдуулав.
- 3.7 Байгууллагын нийт амьтандаа үйлчилгээнд хэрэглэсэн хор бодис, өвчөлтэй болгоомтой хэрэгсэл, үйлчлэгч хийсэн талын мэргэжлийн зөвшөөрлийг уг хор, бодис өсгөлт хүрэхгүй байх, хуучил, хар хэрэгсэл урьдчилан сарниулах талаар арга хэмжээг эхлүүлж байгуулав.
- 3.8 Үйлчилгээ хийсэн өдрөөс эхлэн хор бодисыг буцааж цуглуулах кургал хугацаанд хэрэглэсэн хор бодис, өвчөлтэй хадгалалт, хамгаалалт, түүнтэй холбогдон гарах хариуцлагыг бүрэн харуулав.
- 3.9 Захиалагч байгууллага нь үйлчилгээ авснаас хойш 3 хоногийн дотор бэлэн ба бэлэн бусаар төлбөрийг хийнэ. Нэр: Энх цагийн үйлс" ХХК-ны 5088029616 дугаартай дансанд төлбөрийг хийнэ.

Дөрөв: Гэрээний хугацаа, үнэ тариф

- 4.1 2022 оны 03 сарын 01-ны өдрөөс 2023 оны 03 сарын 01-ны өдөр хүртэл ... жилийн хугацаатай байгуулав.
- 4.2 Гэрээний хугацаа дууссан боловч талууд гэрээг дуусгаар болох тухай нөгөө талдаа албан ёсоор мэдэгдэхгүй бол гэрээг цашид нийл хугацаа нөхцөлдгээр сунгагдсанд тооцно.
- 4.3 Талууд хүчдэнтэн үзэх шалтгаанаар гэрээг цуцлах, өөрчлөх бол 1 сарын өмнө албан ёсоор мэдэгдэх ба талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 4.4.1 Ариутгал халдваргүйжүүлэлт 1 м² талбай 360 төгрөгөөр нийт 500 м² талбай 180000 төгрөгөөр халдваргүйжүүлэлт хийнэ. Бодисын нэр төрлөөс хавсаргана.
- 4.4.2 Шавьж мэрэгч устгал 1 м² талбай 400 төгрөгөөр, нийт 500 м² талбай төгрөгөөр устгал хийнэ. Бодисын нэр төрлөөс хавсаргана.

- 4.4.2 Мэрэгч устгал 1 м² талбай 400 төгрөгөөр, нийт 500 м² талбай төгрөгөөр устгал хийнэ. Бодисын нэр төрлөөс хавсаргана.

Дөрөв: Ариутгал халдваргүйжүүлэлтийн үйлчилгээ нь хугацааны хувьд дараах нөхцөл байдалтай уялдан хийгдэнэ. Үүнд:

- Коронийн цар тасалт үеийн нөхцөл байдалд 14 хоног тутамд
- Урьдчилан сарниулах халдваргүйжүүлэлт: Сар, улиар тутамд
- Болзолгүй асуу: гамшиг, халдвар өвчин голомлог гарсан үед дуудагдаж хийж: Гэрээний тархын дагуу
- Хавар нарын улиралд эдлбэр газрын хөрөнд халдваргүйжүүлэлт хийж

Тав: Хамтран хүлээх үүрэг ба хариуцлага

- 5.1 Хоёр тал гарын үсэг зурж, тамга дарснаар гэрээ хүчин төгөлдөр болно. Гэрээг 2% үлдэнэ.
- 5.2 Ажил үйлчилгээний өвчтэй хамт цашид амьтны 2 талаас гаргах ажлуулна.
- 5.3 Үйлчилгээний чанартай холбогдон гарсан өмнө талд 2 тал хэлцэлцэж, шалтгааныг тогтоон хамтран шийдвэрлэнэ. Асуудлыг шийдвэрлэх боломжгүй бол хууль тохиромжтой байгууллагаар шийдвэрлэнэ.

Гэрээ байгуулсан:

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөгч: Энх цагийн үйлс" ХХК-ийн Мөнхбаяр Б.Доржиев
Утас: 90008810, 90008511
Хаяг: СХД-ийн 1-р хороо Гүнгарваа Худалдааны төв 57 тоот

Захиалагч байгууллагын төлөөлөгч: "Ноос, ноолуур" ХХК-ийн Захирагч С.Ялалт
Утас:
Хаяг: СХД дүүрэг 2-р хороо

Зураг 10. Ариутгал халдваргүйжүүлэлтийн гэрээ

2.1.5. Төхөөрөмжийн засвар үйлчилгээ

Ноолуур боловсруулах үйлдвэр нь шугаман функциональ зохион байгуулалтын бүтэцтэй бөгөөд түүнд түүхий эд /ноолуур/ бэлтгэх ба хүлээн авах, нөөчлөн хадгалах, ангилан ялгаж төрөлжүүлэх, сэгсрэх, угаах, хатаах, самнаж хялгасыг нь ялгах, прессэлж боох зэрэг технологи дараалалтай байна. Тус онд үйлдвэрийн тоног төхөөрөмжинд гэмтэл гараагүй болно.

2.1.6. Ус ашиглалт, гэрээ

Манай байгууллага нь өөрийн талбайд гаргасан гүний худгаас хангадаг ба Нийслэлийн байгаль орчны газартай 2022 оны 09 дугаар сарын 06-ны өдрийн 2022/57 дугаар ус ашиглах гэрээ байгуулан ажилласан. 2022 онд үйлдвэр болон ажилчдын унд ахуйн хэрэглээнд нийт 21909.6 м³ ус ашиглан 2,068,266 төгрөгийг Сонгинохайрхан дүүргийн татварын албанд төлсөн.

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДУГАА
НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ЗАХИРАГЧ
УС АШИГЛАХ ГЭРЭЭ
2022 оны 09 сарын 06-ны өдөр Дугаар 2022/57 Улаанбаатар хот

Нэг: Ерөнхий зүйл:

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 28.1-д заасны дагуу Туул голын сав газрын захиргааны 2022 оны 5 дугаар сарын 31-ны өдрийн 04/357 дугаартай ус ашиглуулах дүнгээг Нийслэлийн Байгаль орчны, хотын өргөтгөлийн газаруудын хорооны даргын 2018 оны 5 дугаар сарын 19-ны өдрийн А/54 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн. Ус ашиглуулагчийг төлөөлж Нийслэлийн Байгаль орчны газрын Ойн хэлтсийн ахилс мэргэжлийн Ойерхээний өсгөлт Төмүүний Ус ашиглагчийг төлөөлж нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо, Автобус 2 дугаар баазын баруун талд, 9011028108 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 50609069 регистрийн дугаартай "Жин корона" ХХК-ийг төлөөлж Н-ба Жонобайр овогтой Цэрэн нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2022 оны 1 дүгээр сарын 01-нээс нөхөн тооцож 2022 оны 12 дугаар сарын 31 хүртэл 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр: Гэрээний гол нөхцөл:

1. Ус ашиглах зориулалт: Ноос ноолуур угаах зориулалтаар усны ашиг хангана.
2. Ашиглах усны хэмжээ:
 - 2.2.1. Нэг өдөр м³/өдөр: 942 м³
 - 2.2.2. Үйлдвэрлэл, жил: 21909.6 м³
 - 2.2.3. Үйлчилгээ м³ /жиг:
 - 2.2.4. Шингэлээ, сувгалгаа, хүл хөөг:
3. Усны чанар, найрлага: 2022 оны 10 дугаар сарын 15-ны дотор багтан гүний худгийн усны хими батлөрлийн шинжилгээ хийлгэх стандартын шаардлага хангасан тохиолдолд үнд ашиг хэрэглэнэ.
4. Усны эх үүсвэрийн:
 - 4.1. Байршил: Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо Сонголонгийн 51 тоот.
 - 4.2. Сойлбоод: 47°54' 18"Н, 106°48'23.30"Е.
 - 4.3. Барилга байгууламж: Үйлдвэрлэлийн зориулалтаар гаргасан гүний худгас өөр усны барилга байгууламж байхгүй.
 - 4.4. Тонг төхөөрөмжийн нэр, марк: ЗНЦ-4 загварын усны насосотой, ДН загварын 50 мм, ХХГ загварын 50 мм голтой усны тоолууртай.
 - 4.5. Хүчин чадал: Хонгт 2.5-3.0 тонн, жилд 500-700 тонн түүхий ноолуур, ноос угаах суурилагдсан хүчин чадалтай.
5. Хяналдаг усны:
 - 5.1. Хэмжээ: Сард 1600 м³ хяналдаг усныг төвлөрсөн шугаманд нийлүүлдэг.
 - 5.2. Стандартын шаардлага: "Ариутгах татуурын сүтээгдэх нийлүүлэх хяналдаг ус: Ерөнхий шаардлага" MS 9561:2015 стандартын шаардлага хангасан хяналдаг усны төвийн коллекторт нийлүүлдэг.
 - 5.3. Хаяг: Хөвдөр байршил: Хотын боир усны төвлөрсөн шугаманд нийлүүлдэг.
 - 5.4. Сойлбоод: 47°54' 18"Н, 106°48'22.80"Е.
6. Хяналдаг усны дахь бохирдуулах бодисын хэмжээ: Усны биохимийн шинжилгээний дүг хавсаргана.
 - 6.1. Жингэлдэх бодис, кг:
 - 6.2. Органы бодон, кг:
 - 6.3. Эрдэс бодис, кг:

- 2.6.4 Хүнд металл, кг:
- 2.6.5 Ариутгай бохирдуулах бодис, бодис, гр:

2.7. Боир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, шаардлах арга, цэвэрлэлийн түвшин: 90 м³ багтаамжтай өмнө шатны сэлтэн тунгавууртай. Тунгавуураар дамжуулан төвлөрсөн шугаманд нийлүүлдэг.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сарниулах арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ: Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд усны нөөцийг хамгаалахад зарцуулах хөрөнгийн хэмжээг тусгаж хэрэгжүүлж амилгах.

2.9. Усны тоолуурын:

- 2.9.1 Төрөл, нэр, дугаар: 1507000098, 1001003373 дугаартай.
- 2.9.2 Загвар: ДН-50, ХХГ-50.
- 2.9.3 Тоолуурын тоо: 2
- 2.9.4 Суурилуулсан байгууллага, өнөө: ДН-50-2019.11.07, ХХГ-50-2021.06.24-нд барилгажуулав.
- 2.9.5 Тоолуурын заалт: 2021 оны 1 дүгээр сарын 01-ны өдрийн байдлаар тоолуурын заалт 9387 м³ байна.

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ: 2022 оны усны нөөц ашигласны төлбөрийг "Усны өсгөлт, эдийн засгийн үнэтгэж шийтгэл" багтаж тухай Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 302 дугаар тогтоолын 1 дүгээр хэсгээр, "Усны нөөц ашигласны төлбөрийн хуви хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай", "Тогтоолын хавсаргалтад өөрчлөлт оруулах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 326, 327 дугаар тогтоолын дагуу 9387 м³-ээс хойш тоолуурын заалтаар тооцож Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ. 1 м³ усны нөөц ашигласны төлбөр 94.4 төг.

2.11. Хяналдаг усны дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ:

Гурав: Талуудын эрх үүрэг:

Гэрээ байгуулах талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдлэл, үүрэг хүлээнэ.

Дөрөв: Бусад:

- 4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж батлаагааруулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 4.2. Ус ашигуулах дүнгээг ус ашиглах зөвшөөрөл, хяналдаг усны талаарх дүнгээг, хяналдаг ус ашигуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дундаж тэмдэглэл үйлдэнэ.
- 4.4. Талуудын тохиролцооноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
- 4.5. Гэрээг дор дүрсэн үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцлах болно.
 - 4.5.1. Ашиглах байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.
 - 4.5.2. Ань нэг тал татан буцагдан бол.
- 4.6. Талуудын хооронд урсган мэдээлэл өгөх, зармаар шийдвэрлэлийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрөл холбогдох шатны шуургаар шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж: Нийслэлийн Байгаль орчны газрын Ойн хэлтсийн ахилс мэргэжлийн Төмүүний Хаяг: СХД-ийн 1-р хороо Гүнгарваа Худалдааны төв 57 тоот Харилцах утас: 99088868, 99904487

Ус ашиглагчийг төлөөлж: "Жин корона" ХХК-ийн Н-ба Жонобайр овогтой Цэрэн нар Хаяг: СХД 20 дугаар хороо Сонголонгийн 51 тоот Харилцах утас: 99088868, 99904487

Усны төлбөрийн тооцоо

Д.д	Гэрээ байгуулсан он	Сав газрын дундаар л/т	Тоолуурын заалтаар л/т	Усны нөөц ашигласны төлбөр /төг/	Тайлбар
1.	2019	2019 оны дундаар 19600	Жилийн өмнө 47298 Жилийн сүүл 58861	1,227,200.00	2019 онд 12/18/21 дугаартай гэрээ байгуулав. Үнд ахуйн ус төвлөрсөн шугамнаас өмнө.
2.	2020	2016 оны дундаар 19800	58881	81107 9528	2020 онд 20/20/21 дугаартай ус ашиглах гэрээ байгуулав.
3.	2021	34507	81107 9387	3,257,480 төгрөгийн усны төлбөр төлсөн.	2021/28 дугаартай ус ашиглах гэрээ байгуулав.
4.	2022	21909			2022/57 дугаартай ус ашиглах гэрээ байгуулав.

Зураг 11. Ус ашиглах гэрээ


**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГАА**
 16050 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо,
Чингунжавын гудамж, Туул голын сав газрын захиргааны байр,
Утас: 7000-3714, Факс: (976) 7000-3714
E-mail: TuulRBA@gmail.com
 2022.05.31 № 04/357
 ТАНХАЙ 2022.05.18-ны № 21/36 -Т

**“ЖИН КОРОНА” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Н.БАТЦЭНГЭЛ ТАНАА**

Монгол Улсын Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалт, танай компанийн 2022 оны 05 дугаар сарын 18 -ны өдрийн 21/36 дугаартай албан бичгийг үндэслэн холбогдох баримт бичгүүдийг судалж үзээд, 2022 оны ус ашиглуулах дүгнэлтийг гарган хүргүүлж байна.

Ус ашиглуулах дүгнэлтээр тавигдсан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллана уу.
Хувийг: Нийслэлийн Байгаль орчны газар, Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтэст.
Хавсралт 3 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮВ
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ **Д.НЯМДОРЖ**



**ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА
“ЖИН КОРОНА” ХХК-ИЙН
УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ**

2022 оны 05 дугаар Дугаар УАД 22/73 Улаанбаатар хот сарын 31 утас: 70003714, 70003716

- 1. Аж хуулин нэгж байгууллага, захирлын нэр хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар:**
- “Жин Корона” ХХК, Захирал Н.Батцэнгэл, утас 9908-8868, 9990-4487 Улсын бүртгэлийн дугаар 9011028109, регистрийн дугаар 5060869.
- 2. Төслийн нэр, байршил:**
- “Жин Корона” ХХК-ийн “Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр” нь Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, автобусны 2-р баазын баруун талд өөрийн байранд байрлана.
- 3. Төсөл хэрэгжүүлэгч:**
- “Жин Корона” ХХК.
- 4. Тусгай зөвшөөрлийн талаар:**
- Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2017 оны А/298 дугаар шийдвэрээр олгосон, 00009585 тоот гэрчилгээтэй 8'435.0 м² га газрыг 15 жилийн хугацаатай үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмшдэг.
- 5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт:**
- Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэл эрхэлдэг.
- 6. Үйлдвэрлэлийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/:**
- Үйлдвэр нь хоногт 2.5 - 3.0 тонн, жилд 500.0-700.0 тонн түүхий ноолуур, ноос угвах хүчин чадалтай.
- 7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:**
- 2022 онд ~850 орчим тонн ноос, ноолуур угаахаар төлөвлөсөн. Үйлдвэр нь 1-12 дугаар саруудад үйл ажиллагаа явуулж, дунджаар 250-300 хоног ажиллана.
- 8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо, метрээр/:**
- Ус хангамжийн эх үүсвэрт ашигладаг хүдсийн мэдээлэл:

Хүдсийн дугаар	Солбицол	Гүн, метр	Ундарга, л/сек	Гаргасан он	Насосны нэр
18130-01593	106°46'23.36"E 47°54'7.18"N	40.0	6.0	2006	QJDI
- 9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц /:**
- Үйлдвэрлэлийн усан хангамжийн зориулалтаар гаргасан гүний худаас өөр усны барилга байгууламж ашигладаггүй.
- 10. Худаа, өргөлтийн станцууд, усны тоолуур /Насосны хүчин чадал, марк/:**
- Ус сувгийн удирдах газартай байгуулсан гэрээний дагуу сар бүр цэвэр, бохир усны тооцоо хийдэг.
- Худаат Стандарт, хэмжил зүйн газраас 2021 оны 12 дугаар сард баталгаажуулсан LXSJ зааварын 50 мм-ийн голчтой 300304 дугаартай тоолуур суурилуулсан. 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн заалт: 9387 м³.
- Төвлөрсөн шугамын орох хоолой дээр LXSJ-50 зааварын 150700069 дугаартай усны тоолуур суурилуулсан.
- 11. Дамжуулах байгууламж /Шувам сүлжээний урт, диаметр, эх үүсвэр/:**
- Үйлдвэрлэлийн технологийн хяналал усан дахь хялвас, лагийг шүүх, тунгаах сараалж бүхий тунгаагуураар дамжуулан төвлөрсөн шугаманд бохир усав нийлүүлдэг.
- 12. Хяналал бохир усны хэмжээ, цэвэрлээний арга, түвшин:**

- УСУГ-ын 2022 оны хэрэглээний тооцооноос үзэхэд сард дунджаар 1'500.0 - 2'000.0 м³ бохир усыг сараалж, тунгаагуураар дамжуулан УСУГ-ын урьдчилан цэвэрлэх байгууламжид нийлүүлдэг.

- 13. Үйлдвэрлэл, үйлчилгээний усны нөөцийг хэмнэх, эрүүлж ашиглах даалгавар:**
- Үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан хяналал бохир усыг дахин ашигладаггүй. Цаашид үйлдвэрлэлийн өөрийн хүчин чадалд тохирсон, бага өврын цэвэрлэх төхөөрөмж суурилуулан ашиглаж байгаа зарим компанийн туршлагыг судалж, санаачлаа гарган ажиллах.
- 14. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:**
- Үйлдвэрлэлийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол мэдээлэл 2018 онд “Хос Санаа” ХХК зүйцэтгэж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамар батлуулсан. Цаашид байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай.
- 15. Онцгой нөхцөл:**
- “Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, Ариутгах татуурын сүлжээнд нийлүүлэх хяналал ус. Ерөнхий шаварлага MNS 6561.2015” стандартаас давсан бохирдолтой хяналал усыг төвлөрсөн сүлжээнд нийлүүлсэн тохиолдолд Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь заалтын дагуу ус ашиглах эрх цуцлагдах нөхцөл үүсэхийг анхаарах;
- 16. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох:**
- 2022 оны ус ашиглалтыг урьдчилсан байдлаар тооцоход:
1-5 дугаар сард ашигласан усны нийт хэмжээ: 9'129.0 м³ /2022 оны УСУГ-ын хэрэглээний тооцооны хуудас/
Сарын дундаж усны хэрэглээ: 1'825.8 м³ /2022 онд ашигласан усны хэмжээнд үндэслэв/
2022 онд ашиглах усны нийт хэмжээ: 1'825.8 м³ /сар х 12 сар = 21'909.6 м³ /жил /Урьдчилсан байдлаар/.
- 17. Холбогдох хууль, тогтоол шийдвэрлэлийн дагуу нөдүүлэх усны нөөцийн төлбөрийн хэмжээ:**
- Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор батлагдсан “Усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ”, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолоор батлагдсан “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ”, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолоор батлагдсан “Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр”-ийг тус тус үндэслэн тооцоход:
Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах 1 м³ усны нөөцийн төлбөрт:
9'440 төг/м³ x 0.1 x 10% = 94.40 төгөөр
9'440 төг/м³ -Туул голын сав газар дахь газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;
10% -Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ;
0.1 -Хөнгөн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд ашиглалтын зориулалтын итгэлцүүр.
- 2022 онд ашиглах усны нөөцийн төлбөрт:**
21'909.6 м³ x 94.40 төг = 2'068'266 /Хоёр сая жаран найман мянаа хоёр зуун жаран зургаан төгрөг.
Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасны дагуу усны нөөцийн төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор ус ашиглах дүгнэлтээр тогтоосон хувь хэмжээгээр (94.40 төг) усны тоолуурын заалтаар Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ.
- 18. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмж:**

- Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу нийслэлийн Байгаль орчны газраас ус ашиглах зөвшөөрөл авч, усаар хангагч байгууллага болох Ус сувгийн удирдах газартай гэрээ байгуулах;


- Ус ашиглуулах дүгнэлтээр нөдүүлсэн усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг хуваагчид нь төлөхөү үйл ажиллагаа явуулбал Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3 дахь заалтын дагуу ус ашиглах эрх цуцлагдах. Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн дагуу харууцлага хүлээх нөхцөл үүсдэгийг анхаарч ажиллах;


- Усны тоолуурын заалтын батлагаа алдагдсан, тоолуурыг шугам хоолойноос салгасан, тоолуурыг үйл ажиллагаа явуулсан тохиолдолд усны нөөц ашигласны төлбөрийг Байгаль орчин, ногоон хөгжил ялал жуулчлалын Сайддын 2015 оны А-301 дүгээр тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-оор тооцож нөдүүлэхийг анхаарах;

- Гэрээнд зааснаас шулу ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор батлагдсан “Зөвшөөрсөн хэмжээгээ шулу ашигласан усны төлбөр тооцох журам”-ын дагуу шалтан өсвөх хэлбэрээр тооцоно;

- Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 17 дугаар зүйлийн 17.1.5-д заасны дагуу сая газрын усны мэдээллийн дэд сан бүрдүүлэхэд шаардлагатай мэдээ тайлан, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тайланга 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Туул голын сав газрын захираагчид ирүүлнэ;

- Ус ашиглуулах дүгнэлтийг тухайн жилийн эхний хагас жилд бөгөөд жил бүр гаргуулж байхыг анхаарах.


ХЯНАСАН:
УСНЫ НӨӨЦ, УС АШИГЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ
АЛБАНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  П.ЭНХБАЯР

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:
УСНЫ НӨӨЦ, УС АШИГЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ
АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН  Д.УРАНЧИМЭГ

Зураг 12. Ус ашиглах дүгнэлт

2.1.7. Бохир усны шинжилгээ

Үйлдвэрээс гарч буй бохир усыг бага оврын цэвэрлэх байгууламжинд нийлүүлэн MNS 6561:2015 ХБО. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага стандартанд нийцүүлэн төвлөрсөн системд нийлүүлж байгаа уснаас бохир усны дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлээ.



Зураг 13. Бохир усны шинжилгээний дүн

Цэвэрлэх байгууламжаас гарсан хаягдал усыг ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэхэд Ус сувгийн удирдах газрын усны төв лабораторид 2 удаа шинжлүүлсэн бөгөөд стандартын ЗДА-с хэтрээгүй буюу цэвэрлэх байгууламж нь үйлдвэрээс гарсан хаягдал усыг MNS 6561:2015 стандартад нийцүүлэн цэвэрлэж байна.

2.1.8. Бага оврын цэвэрлэх байгууламж

Манай байгууллага нь хоногт 100 м³ ус цэвэрлэх хүчин чадалтай бага оврын цэвэрлэх байгууламжийг суурилуулан ашиглаж байна.



Зураг 14. Цэвэрлэх байгууламжийн байр, төхөөрөмж

2.1.9. Ундны усны шинжилгээ

Үйлдвэрийн хэрэглээний усыг өөрийн эзэмшлийн худгаас хангадаг ба 1 дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн дүнг ОХШХ-т тусгав. Ажилчдын ундны усны хэрэглээг УСУГ-ын ус түгээх худгаас зөврөөр авч хангадаг ба ахуйн хэрэглээний усыг төвийн шугамаас ашиглаж байна.

2.1.10. Тунгаагуур цэвэрлэгээ

Үйлдвэрийн ажилчдыг томилон 7 хоногт 1 удаа цэвэрлэгээ хийж байна.

2.1.11. Усны төлбөр

Манай байгууллага нь үйлдвэрийн усан хангамжийг өөрийн эзэмшлийн талбайд байрлах 1 худгаас хангадаг бөгөөд Туул голын сав газартай гэрээ байгуулан дүгнүүлж 2022 онд 2,068,266 төгрөгийг ус ашигласны төлбөр болгон барагдуулаад байна.

ХААН БАНК Огноо/Date: 2022.12.07 16:06:29

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 21533203
Системийн огноо/System Date: 2022.12.07 16:08:50

Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5087122750	Ж*****Ж ЦЭРМАА	2,068,266.00 MNT	1.00
/ Хоёр сая жаран найман мянга хоёр зуун жаран зургаан төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No	Банкны нэр Bank Name		
	05	Хаан Банк		
	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name		
	5176120446	МТА.ТАТВАР	2,068,266.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:
3221200590403; АИ84121101; 99904487

МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА Урьдчилгаа төлбөрийн дугаар : 3221200590403

ТАТВАРЫН АЛБА:
тварын алба: Сонгинохайрхан
тварын дэд алба: Дүүргийн төвлөрсөн
тварын төрөл: 01030724 - Үйлдвэрлэл, үйлчилгээний эрхлэлтээр ашигласан усны төлбөр
ийлэнт хугацаа: 2022 - 1

ТАТВАР ТӨЛӨГЧ:
Регистр /ТТД: 5060869 / 76000854064002
Татаар төлөгчийн нэр: ЖИНКОРОНА
Нэхэмжлэх үүсгэсэн огноо: 2022-12-07 16:06:29
Төлөх огноо: 2022-12-07 16:06:29



3221200590403

Зураг 15. Ус ашигласны төлбөрийн баримт

2.1.12. Хөрсний шинжилгээ

Үйлдвэрийн гадна талбайд 1 цэгээс хөрсний хими физик, хүнд металлын шинжилгээг авсан. Дэлгэрэнгүйг ОХШХ-т тусгав.

2.1.13. Гадна талбайн цэвэрлэгээ

Үйлдвэрийн ажилчдыг нэгдсэн байдлаар сард 1 удаа цэвэрлэгээ хийж байна.

2.1.14. Хог хаягдлыг цуглуулан тээвэрлэх

Үйлдвэрийн талбайд хатуу хучилттай талбайг байгуулсан хөрсөнд нэвчихгүй байдлаар хаягдлыг цуглуулан Сонгинохайрхан дүүргийн ОНӨТҮГ -тэй байгуулсан гэрээний дагуу сард 1 удаа зайлуулж байна.

ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Манай байгууллага нь тус онд эзэмшил талбайд ногоон байгууламж бий болгох, тохижилтийн ажлын хүрээнд үйлдвэрийн байрны гадна цэцгийн мандал, улиас, хайлаас зэргийг тариалан арчлан үйл ажиллагаанаас гарсан хаягдал материалаар тохижуулалтын ажлыг гүйцэтгэсэн.

Хүснэгт 2. Орчны тохижилт, ногоон байгууламжын төлөвлөгөөний биелэлт

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Биелэлт	Хувь
1	Орчны үзэмжийг сайжруулах, тоосжилтоос сэргийлэх, мод тарих	Цэцгийн мандал байгуулах	Үйлдвэрийн байрны гадна талбайд 2 төрлийн цэцгийн мандал байгуулан тохижуулсан.	100%
		Мод тарих	1-2 насны Улиас-5 ширхэг, Хайлаас-5 ширхэг суулгац авч тарив. Одоогоор үхсэн суулгац байхгүй байна.	100%
2		Зүлэгжүүлсэн талбайд арчилгаа хийх	Суулгац тариалсан талбайг тойруулсан зүлэгний үр цацсан бөгөөд байгалийн аясаараа тодорхой тооны зүйлийн ургамал мөн ургасан. Ногоон байгууламжийн арчилгаа тордолтыг тогтмол гүйцэтгэж байна.	100%



Зураг 16. Ногоон байгууламжын талбай



Зураг 17. Ногоон байгууламжын талбай

ДӨРӨВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Манай байгууллагын хүрээнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг тоног төхөөрөмжтэй харьцаж ажилладаг тул байгууллагын хөдөлмөр аюулгүй байдал анхаарч ажилладаг билээ. Иймд ч байгууллагын үйл ажиллагаанд Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны стандартуудыг баримтлан ажиллаж байна.

Үйлдвэрт осол, эрсдэлийн менежмент төлөвлөгөөг 2 чиг үүргээр баримтлан ажилладаг. Үүнд:

1. Ажилчдын аюулгүй байдал, хамгаалах хэрэгсэл, сургалт
2. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа

Тус онд дээрх 2 чиг үүргийг баримтлан дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Хүснэгт 3. Осол, эрсдэлийн менежмент төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Биелэлт	Хувь
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн ажиллагааг өдөр тутам тогтмол шалгаж мэргэжлийн хамт олноор жилд 1 удаа химийн бодистой харьцах, тоног төхөөрөмжтэй харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулж байна.	%
	Галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт		
	Үйлдвэрийн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт		
Технологийн хоцрогдол	Үйлдвэрийн ажилчдад химийн бодистой ажиллах, аюул ослын үед авах арга хэмжээний сургалт	Үйлдвэр болон төслийн талбайд гал унтраах бүрэн тоноглогдсон сараалж 1, галын хор 3, сануулга самбар байршуулсан.	%
	Гал унтраах хэрэгслээр үйлдвэрийг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах		



Зураг 18. Гал унтраах хэрэгсэл

Үйлдвэрт ажиллаж буй ажилчдад өдөр тутамдаа резинэн бээлий, даавуун бээлий, нэг удаагийн амны хаалгаар хангадаг. Мөн дараахь хамгаалах хэрэгслээр тодорхой хугацааны давтамжтай элэгдэл харгалзан хангаж байна.



Зураг 19. Хөдөлмөр аюулгүй байдлын хувцас хэрэгсэл

Ажилчидыг 5 баг болгон хувааж гал гарсан тохиолдолд хэрхэн анхны тусламж үзүүлэх, галыг унтаарах талаар буухиа тэмцээнийг зохион байгуулж ажилчидын авхаалж самбаа, галын талаарх мэдлэг чадварыг сорьж сургалтын үр дүнг тооцон ажиллаа.



Зураг 22. Практик сургалт

Сургалтын шилдэг сурагч ажилтанаар Ээлжийн ахлагч, квошийн оператор П.Даваадорж, Машин баригч Г.Дөлгөөн, Г.Бямбахүү, Б.Батням, Байгаль орчны ажилтан Л.Золжаргал нар шалгарч СХД-ийн Онцгой байдлын хэлтсийн өргөмжлөлөөр шагнуулж, байгуулагаас мөн мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.



Зураг 23. Практик сургалт

ТАВ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 4. Хог хаягдлын менежмент төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Биелэлт	Хувь
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Хатуу хог хаягдлыг ялгах, зайлуулах, дахин боловсруулалтад оруулах талаар менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Тус онд хатуу хог хаягдлын цэгийг хатуу хучилттай ангилан ялгадаг таславчтай битүү байгууламж байгуулахаар төлөвлөн талбайг бэлтгэн ажиллаж байна.	20%
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Шингэн хаягдлыг зайлуулж буй цэвэршүүлэх байгууламжтай холбогдож буй шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж засвар үйлчилгээг хийж байх, нийлүүлж буй бохир усны найрлагад хяналт тавих	Ус сувгийн удирдах газрын усны төв лабораторид 2 удаа шинжилгээг гүйцэтгүүлсэн ба MNS 6561:2015 стандартын зөвшөөрөгдөх дээд агууламжаас хэтрээгүй байна.	100%

ЗУРГАА. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Хүснэгт 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

№	Хянах үзүүлэлтүүд	Биелэлт	Хувь
1	Агаарын чанар: Агаарын бохирдлын шинжилгээ, дуу чимээний хэмжилтийг хийлгэж байх. БОШТЛ-ын багажаар./	Үйлдвэрийн хашаан дотор 2022.05.04-ны өдөр ЦУОШГ-ын Байгаль орчны хэмжил зүйн төв лабораториор хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос, дуу чимээний хэмжилтыг 20 минутын турш хийлгэсэн.	100%
2	Усны хяналт шинжилгээ	Төслийн талбайд байрлах гүний худгаас 2022.05.04-ны өдөр усны дээж авч “Инженер геодези” ХХК-ийн Ус судлалын итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжлүүлсэн	100%
3	Хөрсний төлөв байдал, бохирдол	Үйлдвэрийн байрны гадна талбайн өнгөн хөрснөөс 2022.05.04-ны өдөр дээж авч “Инженер геодези” ХХК-ийн Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид агрохими, хүнд металлын шинжилгээг хийлгэсэн.	100%

6.1. Агаарын шинжилгээ

Үйлдвэрийн хашаан дотор 2022.05.04-ны өдөр ЦУОШГ-ын Байгаль орчны хэмжил зүйн төв лабораториор хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос, дуу чимээний хэмжилтыг 20 минутын турш хийлгэсэн. Тус шинжилгээний дүнгээр Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй буюу бохирдолгүй гарсан.



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bobztl@gmail.com
СОРИЛТЫН ДҮН



Дугаар он/№ : 2022/A-110

Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Хос Санаа” ХХК

Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхшиг агаарын хэсэг

Дээжийн тоо, төрөл : 1 агаар, 1 дуу чимээ

Сорьц авсан огноо : 2022.5.4

Дээжийн тодорхойлолт : СХД, 20-р хороо, Сонголлонгийн гудамж, “Корона” ХХК
Ноос, ноолуур угаах үйлдвэр

Шинжилгээний аргын стандарт : MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021
CA3 A07-2016

Шинжилсэн огноо : 2022.5.6

Хуудасны тоо : 1/1

Үр дүн :

№	Сорьц авсан цаг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м³	Азотын давхар исэл мг/м³	Нийт Тоос TSP/ мг/м³	Дуу чимээ /ДБА/
1	Үйлдвэрийн хашаан дотор	V/4	12:40	0.010	0.021	0.057	40
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн:
Агаарын хэсгийн инженер

Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга.


 Д.Тумэндэлгэр
 Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

Зураг 24. Агаарын шинжилгээний дүн


6.2. Усны хяналт шинжилгээ

Үйдвэрлэлийн хэрэглээний усыг хангахаар үйлдвэр дотор 1 гүний худаг гарган тохижуулсан ба тус худгаас 2022.05.04-ны өдөр усны дээж авч “Инженер геодези” ХХК-ийн Ус судлалын итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжлүүлсэн.




Зураг 25. Үйлдвэрийн худаг

Шинжилгээний дүнгээр химийн бүрэлдэхүүнээрээ сульфатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, хатуу ус байна гэж гарсан байна.



**ХӨРС СУДЛАЛЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**



ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК
Утас/Факс: 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

Дугаар: 22/1695

Дээж авсан огноо: 2022 он 05 сарын 04
Шинжилгээ хийсэн огноо: 2022 он 05 сарын 05-06
Дээж авсан газрын нэр: Уланбаатар хот, СХД, 20-р хороо, ноос ноолуур угаах үйлдвэр
Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Жин Корона” ХХК
Харилцах утас: 99019797
Уст нэгдлийн төрөл ба дугаар: Худаг
Координат: -
Лаб № 22/2972

Усны химийн задлан шинжилгээний дүн

Анион	мг/л	мг/экв	%, мг-экв/л	Катион	мг/л	мг/экв	%, мг-экв/л
Cl ⁻	60.97	1.72	21.19	Na ⁺ +K ⁺	17.78	0.77	9.54
SO ₄ ²⁻	172.60	3.59	44.34	NH ₄ ⁺	0.10	0.01	0.07
NO ₃ ⁻	49.19	0.79	9.79	Ca ²⁺	116.23	5.80	71.56
NO ₂ ⁻	0.03	0.00	0.01	Mg ²⁺	18.24	1.50	18.51
CO ₃ ²⁻	0.00	0.00	0.00	Fe ²⁺	0.20	0.01	0.13
HCO ₃ ⁻	122.04	2.00	24.68	Fe ³⁺	0.30	0.02	0.20
Дүн	404.84	8.11	100.00	Дүн	152.85	8.11	100.00

Анион катионуудын нийлбэр: 557.69 мг/л
HCO₃⁻ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 496.7 мг/л
Хуурай үлдэгдэл: 658.0 мг/л
Ерөнхий хатуулаг: 7.30 мг-экв/л
pH: 7.16
Исэлдэх чанар: 0.64 мг/л


Усны физик шинж, чанар

Шүүгдэсний өнгө: Үгүй
Үнэр: Үгүй
Амт: -
Булингар: Тунгалаг
Тундаас: Үгүй

Усны давсны химийн найрлагын томъёо M 658.0 мг/л = $\frac{50.44 \text{ Cl } 21}{Ca 71}$

Тайлбар

Химийн бүрэлдэхүүнээрээ сульфатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, хатуу ус байна. Шинжилгээ хийсэн арга стандартаг: (MNS 1097:1970, MNS 6271:2011, MNS ISO 10523:2001, MNS ISO 9297:2005, MNS ISO 6059:2005)


Лабораторийн эрхлэгч:  Л.Цагаандархи /MS.c/
Задлан шинжээч: О.Алтанцэцэг /MS.c/

Зураг 26. Усны шинжилгээний дүн

6.3. Хөрсний шинжилгээ

Үйлдвэрийн байрны гадна талбайн өнгөн хөрснөөс 2022.05.04-ны өдөр дээж авч “Инженер геодези” ХХК-ийн Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид агрохими, хүнд металлын шинжилгээг хийлгэсэн.

Шинжилгээний дүнгээр үйлдвэрийн талбай нь дунд шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламжаар бага, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй хүнд металлын бохирдолгүй хөрс байна гэж гарсан байна.



Зураг 27. Хөрсний шинжилгээний дүн

Үйлдвэрийн талбайд хийгдсэн 2022 оны орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд авсан дээжнүүдээс холбогдох стандарт давсан агууламж илрээгүй буюу үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинг бохирдуулсан нөлөөлөл одоогоор байхгүй байна.

ДҮГНЭЛТ

Манай байгууллага нь ноос, ноолуур угаан боловсруулах үйлдвэр төслийг Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт өөрийн эзэмшлийн 0.84 га талбайд үйл ажиллагааг явуулж байна. Үйлдвэр нь бүрэн хүчин чадлаараа ажиллахад жилд 700 тн ноос, ноолуур боловсруулах ба энэ онд 573 тн ноолуур угаагаад байна.

Үйлдвэрийн үйл ажиллагааны хүрээнд 2022 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөний 90 орчим хувийг гүйцэтгэн ажилласан ба хог хаягдлын менежмент төлөвлөгөөний хүрээнд хатуу хучилттай ангилан ялгах зориулалтын талбайг байгуулахаар бэлтгэл ажлыг гүйцэтгэж байна.

2022 онд манай байгууллага нь байгаль орчныг хамгаалах менежмент төлөвлөгөөний хүрээнд нийт 6,500,000 орчим төгрөгийг зарцуулсан байна.